

## ГАРЧИГ

<b>НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b>	<b>2</b>
1.1 Төслийн нэр:	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгч	2
<b>ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ</b>	<b>3</b>
2.1 Тоног төхөөрөмж	3
2.2 Байришил	6
<b>ГУРАВ. ХОГ ХАЯГДАЛ</b>	<b>9</b>
3.1 Хатуу хог хаягдал	9
3.2 Шингэн хог хаягдал	Error! Bookmark not defined.
<b>ДӨРӨВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ</b>	<b>11</b>
4.1 Төслийн болзошгүй нөлөөлөл	11
4.2 Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгтгэл, дүгнэлт	Error! Bookmark not defined.
<b>ТАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ</b>	<b>15</b>
5.1 Зорилго	15
5.2 Зорилт	15
5.3 Хамрах хүрээ:	15
5.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
5.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ	18
5.6 Нуулгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ	18
5.7 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ	18
5.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ	19
5.9 Орчины хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний ур дүнг тайлagnaх, хэлэлцүүлэх төлөвлөгөө	21
Хавсралт материалын жагсаалт	Error! Bookmark not defined.
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b>	
Хүснэгт 1 Талбайн солбилцол	Error! Bookmark not defined.
Хүснэгт 2 Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж	3
Хүснэгт 3. Хатуу хог хаягдлын тооцоо	Error! Bookmark not defined.
Хүснэгт 4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгтгэл	Error! Bookmark not defined.
Хүснэгт 5 2022 оны БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн	Error! Bookmark not defined.
Хүснэгт 6 Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ	16
Хүснэгт 7 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ	18
Хүснэгт 8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 9 Удирдлага зохион байгуулалт ба осол эрсдлийн төлөвлөгөө	21
Хүснэгт 10 Орчины хяналт шинжилгээний хөтөлбөр	21
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	
Зураг 1 Тээврийн баазын кемп байрлах талбайн байршилын зураг	2
Зураг 2 Төслийн талбайн өнөөгийн нөхцөл байдал-1	7
Зураг 3 Төслийн талбайн өнөөгийн нөхцөл байдал-2	7

Зураг 4 Төслийн талбайн өнөөгийн нөхцөл байдал-3.....8

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 1.1 Төслийн нэр:

"Пестицидийн үлдэгдэл тодорхойлох лаборатори болон өндөр мэдрэмжит багажит анализыг нутагшуулах, шаардлагатай химийн бодисуудыг импортлох, ашиглах, худалдаалах" төсөл

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгч

"Инно хими лаб" ХХК

**Улсын бүртгэлийн дугаар:** 9011854699


**Регистрийн дугаар:** 8395063

**Хаяг:** Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Бармаш барилгын 3 давхар 301 тоот

**Холбогдох утас:** 77111155, 88885590

**Төсөл хэрэгжих талбайн байршил:** Хан-уул дүүрэг 3-р хороо, Бармаш барилгын 3 давхарт

Зураг 1 Тээврийн баазын кемп байрлах талбайн байршилын зураг



## ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Төслийн хүрээнд нийт 7 ажилтан ажиллах бөгөөд дотоодын болон импортын таримал хүнсэнд пестицидийн үлдэгдэл тодорхойлно. Хоногт 8-40ш дээжид шинжилгээ хийх хүчин чадалтай. Лаборатори ашиглалтад ороод удаагүй байгаа бөгөөд одоогийн байдлаар 8 ш дээжид өдөртөө шинжилгээ хийж, 50-140 нэр төрлийн үзүүлэлт тодорхойлон ажиллаж байна.

### 2.1 Тоног төхөөрөмж

Хүснэгт 1 Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж

№	Төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Үйлдвэрлэсэн улс	Зураг
1	Хийн хроматографи	1	АНУ	
2	Шингэний хроматографи	1	АНУ	
3	pH метр	1	БНХАУ	
4	Аналитик жин	1	БНХАУ	

№	Төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Үйлдвэрлэсэн улс	Зураг
5	Вакум насос	1	БНХАУ	
6	Диспенсер	1	БНХАУ	
7	Соронзон хутгуур	1	БНХАУ	
8	Татах шүүгээ	1	БНХАУ	
9	Ультрасоник/	1	БНХАУ	

№	Төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Үйлдвэрлэсэн улс	Зураг
10	Ус ионгүйжүүлэгч	1	БНХАУ	
11	Үүршуулагч	1	БНХАУ	
11	Хатаах шүүгээ	1	БНХАУ	
12	Холигч	1	БНХАУ	

№	Төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Үйлдвэрлэсэн улс	Зураг	
12	Центрифуги	1	БНХАУ		
14	Чийг хэмжигч	1	БНХАУ		
15	Электрон жин	1	БНХАУ		
16	Термометр	1	БНХАУ		

## 2.2 Байршил

Төслийн талбай нь Хан-Уул дүүргийн 3-р хороо, Бармаш ХХК-ийн байранд, лабораторийн талбай болон химийн бодисын агуулахын байр түрээслэн үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөсөн. Талбайн ойр орчимд агуулах болон үйлдвэрийн зориулалт бүхий газрууд байдаг. Төслийн талбай нь 24 цагийн харуул хамгаалалттай, 3 ээлжийн харуул ажилладаг, үүдний талбайн тоосжилт үүсэхээс хамгаалж хатуу хучилттай болгон тохижуулсан байна. Өмнөговь аймгийн Ханбогд сум нь 15,151 km<sup>2</sup> нутаг дэвсгэрийг эзлэн байрладаг. Улаанбаатар хотоос 650 км, Өмнөговь аймгийн төвөөс 250км зайдайд оршино.



Зураг 2 Төслийн талбайн үүдэн хэсэг



Зураг 3 Төслийн хүрээнд хэрэглэх химийн бодисын агуулах



Зураг 4 Химийн бодисын агуулах



Зураг 5 Лаборатори



Зураг 6 Лаборатори

## ГУРАВ. ХОГ ХАЯГДАЛ

### 3.1 Төслөөс гарах хог хаягдал

Төслийн хүрээнд энгийн болон аюултай хог хаягдал гэсэн 2 төрлийн хаягдал гарна. Энгийн хог хаягдал нь хатуу, шингэн гэсэн үндсэн 2 төлөв байдлаар гарна.

#### 3.1.1 Энгийн хог хаягдал

Уг төслийн хүрээнд нийт 7 хүн ажиллана гэж төлөвлөсөн. Ажилчдаас гарах хог хаягдал буюу ахуйн хатуу хог хаягдлын тооцоог доорх хүснэгтээр харуулав. Хоногт нэг хүнээс 0.3 кг хатуу хог хаягдал гарна гэж тооцвол ахуйн хэрэглээнээс гарах хатуу хог хаягдлын хэмжээ

/Нийт 7 хүн тоогтмол ажиллахаар тооцов /нь:

Хүснэгт 2 Хатуу хог хаягдлын тооцоо

Ажиллах хүний тоо	Хоногийн норм /кг/	Хоногт гарах хэмжээ /кг/	Сард /кг/	Жилд /кг/
7	0.3	2.1	46.2	554.4

Ажилчдаас гарах ахуйн хатуу хог хаягдлыг Хан-Уул дүүргийн ТҮК-тай байгуулсан "Хог хаягдал тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээ"-ний дагуу хог хаягдлыг ачиж тээвэрлэж зайлзуулахаар төлөвлөсөн.

**Зөвлөмж:** Цаашдын үйл ажиллагаанд хатуу хог хаягдлын цэгийг салхины зонхилох зүгийн доор төлөвлөн талбайг хатуу хучилттай болгон ахуйн хог хаягдал салхиар тарж орчин бохирдуулахгүй байхаар битүүмжлэлтэй хогийн савыг байрлуулах зүйтэй юм.

**Шингэн хаягдал буюу ахуйн бохир ус**

Ахуйн бохир усны хэрэглээ нь цэвэр усны хэрэглээтэй уялдаж тооцоологддог.

Хүснэгт 3 Усны хэрэглээний тооцоо

№	Үзүүлэлт	Хоногийн хүчин чадал	Ажиллах өдөр	Усны норм м3/л	Сард ашиглах ус, м <sup>3</sup>	Жилд ашиглах ус, м <sup>3</sup>
1	Ажилтан	7	22	0.3	46.2	554.4

(\*- БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт "Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын ус хэрэглээний норм – Лаборатори 300 ажилтан/л)

Хүснэгт 4 Шингэн хаягдал буюу бохир усны тооцоо

№	Үзүүлэлт	Хоногийн хүчин чадал	Ажиллах өдөр	Усны норм м3/л	Сард ашиглах ус, м <sup>3</sup>	Жилд ашиглах ус, м <sup>3</sup>
1	Ажилтан	7	22	0.21	32.34	388.1

Дээрх тооцооллын батлагдсан нормын дагуу бодож гаргасан болно. Тухайн төсөл хэрэгжих явцдаа жилд 554.4 тн цэвэр ус ашиглах бөгөөд 388.1 тн бохир ус гаргахаар тооцоологдлоо. Цэвэр бохир усны төлбөр тооцоог холбогдох гэрээний дагуу барагдуулан ажиллах нь зүйтэй.

### 3.1.2 Аюултай хог хаягдал буюу химийн бодисын сав баглаа боодол

Төслийн хүрээнд лабораторийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдал болон импортлон хадгалан, ашиглах, худалдаалах бодисуудаас гарах сав баглаа боодол нь аюултай аог хаягдалд хамаарагдах юм. Химийн бодисоо БНХАУ-аас нийлүүлэлт хийх бөгөөд Эрээн боомтоор оруулж ирхээр төлөвлөж байгаа. Дараах хүснэгтээр импорт хийх химийн бодисын савлагaa болон аюултай хог хаягдлын хэмжээ, дахин боловсруулаад зарцуулагдах төлбөрийн тооцооллыг харуулав.

Хүснэгт 5 Аюултай хог хаягдлын тооцоо

№	Аюултай хог хаягдал тээвэрлэх					Аюултай хог хаягдал устгах /дахин боловсруулах/	
	Савлагааны төрөл	Бодисын хэмжээ /тн/	Хаягдал савын тоо хэмжээ /кг/	Нэгж үнэ /₮/	Нэгж үнэ /₮/	Нэгж үнэ /₮/	Нэгж үнэ /₮/
1	Хуванцар сав	1678.1	5500.0	2,700	14,850,000	80000	8,800,000
2	Шил	2382.6	2382.6	3,200	7,624,240	80000	3,812,120
3	Ацетонитрил	-	4.8	7,000	33,600	80000	7,680
4	Метанол	-	2.4	7,000	16,800	80000	3,840
5	Шиприз, зүү, шипризний мембранный фильтр	-	3.6	2,700	9,720	80000	5,760
6	Пестицидийн хаягдал	-	1.2	7,000	8,400	80000	1,920
7	Quechers-ийн давс	-	3.6	7,000	25,200	80000	5,760
8	Нийт	4060.7	7898.2		22,567,960		12,637,080
9	Нийт					-	35,205,040

Химийн аюултай хог хаягдлын хэмжээг жилд нийлүүлэх бодис урвалжаас гарах сав баглаа боодол болон лабораторийн шинжилгээнээс гарах хог хаягдлын нийт хэмжээнд тооцсон болно. Тооцоолсон

хэмжээ болон хог хаягдлын мөнгөн дүн нь нийлүүлэлт, хэрэглээний тухай цаг үеийн байдлаас хамааран хэлбэлзэх магадлалтай болно.

## ДӨРӨВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

### 4.1 Төслийн болзошгүй нөлөөлөл

Төслийн гол сөрөг нөлөөллийг химийн бодис импортлооос эхлэн худалдан борлуулах хүртэлх бүхийл үе шатанд авч үзэв. Үүнд богино хугацааных боловч нөхөн сэргээх хугацаа шаардах нөлөөллүүд, тэдгээрийн эрчим, хамрах хүрээ, хугацаа нь үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын арга, хэрэглэж байгаа тоног төхөөрөмжийн сонголт зэрэгтэй ихээхэн хамааралтай байна. Төслийн үйл ажиллагааны явц дахь нөлөөлөл нь үйл ажиллагаа эрхлэгчдийн ажлын туршлага, дүрэм журмын хэрэгжилт зэргээс ихээхэн хамаарна.

Хүснэгт 6 Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1.	Химийн бодисын хаягдал, хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Орчны хөрс, гүний ус	Төслийн талбайн орчимд	Бага	Хавар, намар, зуны улиралд
2.	Химийн бодисын буруу хадгалалт	Агаар, ус, хөрс, хүн	Агуулахын ойр орчимд	Их	Төслийн туршид
3.	Химийн бодисын тээвэрлэлтийн үеийн гэнэтийн осол	Хүн, байгаль	Төслийн хэмжээнд	Их	Тогтоох боломжгүй
4.	Химийн бодисын хэрэглээ	Хүн, байгаль	Төслийн хэмжээнд, хэрэглэгч	Их	Тогтоох боломжгүй

Эндээс үзэхэд тус төсөл хэрэгжүүлэгч хамгаалалтыг сайжруулах, бодис тээвэрлэлтийг зөвхөн тогтоосон маршрутаар явуулах шаардлагатай. Төслөөс гарах аюултай хог хаягдалд онцгой анхааран хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай харагдаж байна.

Хүснэгт 7 Төслийн гол сөрөг нөлөөллүүд

Үйл ажиллагаа	Химийн бодисын гол сөрөг нөлөөлөл	
	Хүний эрүүл мэндэд	Байгаль орчинд
Химийн бодис ашиглах үед	- Арьс, нүд хамар хоолойг цочроох - Залгихад хортой, урагт нөлөөлж болзошгүй - Удаан амьсгалбал амьсгалын замын эрхтэн системийг гэмтээж болзошгүй	- Усан орчинд нөлөөлөл үзүүлэх - Усны амьтдад нөлөөлөх - Усан орчны организмд удаан хугацаагаар нөлөөлнө.

Үйл ажиллагаа	Химийн бодисын гол сөрөг нөлөөлөл	
	Хүний эрүүл мэндэд	Байгаль орчинд
Агуулахад химийн бодис хадгалах үед	<ul style="list-style-type: none"><li>- Ажиллагсад химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар мэдлэггүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлгүй ажиллах үед бодис асгараах, нүдэнд хүрэлцэн цочроох, хурц болон ужиг архаг хордлого зэрэг эрсдэл үүсэж болзошгүй</li><li>- Төслийн үйл ажиллагааны явцад ажиллагсдын анхаарал болгоомжгүй үйл ажиллагааны улмаас бодис асгараах улмаар галын аюул үүсвэл шаталтын дунд хорт хий ялгаруулж байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.</li><li>- Ажиллагсдын дотоод журмын зөрчил, ажлын хариуцлага алдах зэргээс дээрх эрсдэл үүсэж болзошгүй.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын үеийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол аюулын улмаас химийн бодис уурших замаар агаар, хөрсний хими, физик шинж чанарыг өөрчлөх, бохирдуулах, орчинд тархах</li><li>- Химийн бодисын сав баглаа боодол болон ахуйн хог хаягдлыг журмын дагуу зайлцуулж, устаагүй, ил задгай хаях зэргээс байгаль орчинд бохирдол үүсэж болзошгүй.</li><li>- Агаарт эвгүй үнэр тархаах болон хийн бохирдол үүсгэх</li></ul>
Лабораторийн Үйл ажиллагаа явагдаж байх үед	<ul style="list-style-type: none"><li>- Лабораторийн шинжээчид химийн бодистой буруу харьцах аюулгүй ажиллагааны заавар дагаж мөрдөөгүйгээс эрүүл мэндэд ямар нэгэн гэмтэл, хоруу чанар үзүүлэх</li><li>- Химийн бодистой ажиллах мэргэжлийн техник ажиллагаа алдагдсанаас болж арьс, амьсгалын замаар бодист өртөх</li><li>- Химийн бодисын буруу хэрэглээ, технологийн алдаа гаргаж орчиндоо аюул үүсгэх</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Лабораторийн үйл ажиллагаанаас хамааран байгаль орчинд шууд бус сөрөг нөлөөлөл агаар, усаар дамжин нөлөөлөх эрсдэлтэй</li><li>- Агаарын бохирдол, ус, хөрсний бохирдол</li></ul>
Химийн бодисын худалдаа, борлуулалтын үед	<ul style="list-style-type: none"><li>- Химийн бодис худалдаалах үед хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл өмсөхгүй байх</li><li>- Худалдан авагч талд тухайн бодистой ажиллах хор аюулын лавлах мэдээлэл дагалдуулан өгөхгүй байх</li><li>- Нэр төрөл андуурч өгөх, хэрэглэх явцад алдаа гаргах</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Худалдан борлуулсан химийн бодисын сав баглаа боодлыг эгүүлэн татаж аваагүйгээс химийн хортой, аюултай хог хаягдал байгальд замбараагүй хаягдах</li><li>- Борлуулалтын үед тээвэр зөөвөрт алдаа гарах, хөрс, ургамал, агаар бохирдуулах</li></ul>
Төслюөс гарах аюултай хог хаягдал, түүний зохицуулалтын үед	<ul style="list-style-type: none"><li>- Аюултай хог хаягдаас үүсэх орчны бохирдол, хордлого</li><li>- Химийн сав баглааг устгалд оруулахгүй дахин ашиглах, хүнс ахуйн хэрэглээнд хэрэглэх, хордох</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Аюултай хог хаягдал ил задгай хаяж хөрс, ургамал, агаар бохирдуулах</li><li>- Хортой хийн ууршилт явагдаж агаар бохирдох</li></ul>

## 4.2 Гол сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллахаас гадна химийн бодисын онцлог шинж чанар, хор аюул, хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт талаар ажиллагсдад мэдлэг олгож, болзошгүй сөрөг нөлөөлөл, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний талаар дотоод дүрэм, журам боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй.

Хүснэгт 8 Сөрөг нөлөөллийн урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
1.	Энгийн хог хаягдлаас үүдэлгэй орчны бохирдол үүсэх. Хог хаягдал ил задгай хаях, хог хаягдлын цэгт ариутгал халдвартгэл хийхгүй байх, тогтмол хугацаанд зайлцуулаагүйгээс элдэв шавж үржих, халдварт өвчний эх үүсгэвэр болох	<ul style="list-style-type: none"><li>- Зориулалтын тусгай цэг тохижуулах</li><li>- Тогтсон хугацааны давтамжтай, тогтмол ачин зайлцуулах</li><li>- Хогийн цэгт байнга ариутгал халдвартгүйжүүлэлт хийх</li><li>- Зориулалтын бус газарт шатааж агаар орчин бохирдуулахгүй байх</li><li>- Ил задгай хаяж орчныг бохирдуулахгүй байх</li><li>- Эх үүсвэр дээр нь ангилан ялгах</li><li>- Дахиврыг хэрэглэгч байгууллагад дахин боловсруулахаар шилжүүлэх</li><li>- Хотын стандартыг хэрэгжүүлэн ажиллах "Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент UCS 1701A"</li></ul>
2.	Химийн бодисыг санаатай болон санамсаргүй байдлаар асгах, алдах үед агаар ус, хөрс бохирдох	<ul style="list-style-type: none"><li>- Агуулахын агааржуулалтын ажиллагааг байнга хянаж хэвийн ажиллагаатай байлгах, агааржуулалтын систем мембран шүүлтүүртэй байх, тогтмол хугацаанд сольдог байх.</li><li>- Бодис хадгалах савыг битүүмжлэл сайтай байлгах</li><li>- Хадгалах, тээвэрлэх, худалдаалах, ашиглах үеийн аюулгүй ажиллагааны заавар боловсруулан мөрдөж ажиллах</li><li>- Агуулахыг хариуцсан мэргэжлийн хүн ажиллуулах</li><li>- Бодисын хор аюулын талаарх мэдээлэл, танилцуулах самбар тэмдэг тэмдэглэгээг агуулахад ил байршуулах</li><li>- Химийн бодистой холбоотой сургалт семинар байнга зохион байгуулах</li><li>- Хөрсөнд, гадаргын болон газрын доорх усанд алдахгүй байх</li></ul>
3.	Химийн бодистой харьцах үед санамсаргүй байдлаар өртөх, хүн амьтанд хортой аюултай нөлөө үзүүлэх	<ul style="list-style-type: none"><li>- Химийн ШҮ, химийн бодисын талаар суралцсан мэргэжлийн хүн ажиллуулах</li><li>- Бодисын хор аюул, нөлөөллийн талаарх мэдээ мэдээлэл өгөх сургалт байнга зохион байгуулах</li><li>- Байгальд ил задгай хаяхгүй байх</li><li>- Бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгөх</li><li>- Зааварчилгаа, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих</li><li>- Болзошгүй осол эрсдэлээс ямагт урьдчилан сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах, эрсдэл тохиолдсон үед хэрэглэх хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах.</li></ul>
4.	Химийн бодисоор бохирдсон хортой, аюултай хог хаягдал гарах	<ul style="list-style-type: none"><li>- Аюултай хог хаягдал үүсгэгчийн код авах</li><li>- Хог хаягдлын тухай хуулийг мөрдөж ажиллах</li><li>- Химийн бодисын сав баглаа боодлыг худалдан авагч нараасаа тоо ширхгээр нь буцаан татан авч түр хадгалах.</li><li>- Аюултай хог хаягдал цуглувулж түр хадгалах тусгай цэг, хадгалах агуулах бий болгож хяналттай байлгах</li><li>- Химийн бодисоор бохирдсон материал, эд зүйл, хугацаа дууссан бодис урвалж зэрэг аюултай хог хаягдлыг ангилан хадгалах</li><li>- Бохирдсон бүх зүйлийг тусгайлсан хогийн цэгт түр хадгалах</li><li>- Аюултай хог хаягдлыг хуульд заасны дагуу хэмжээнээс хамааран 90 хоног хүртэл хадгалах</li><li>- Эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай эрх шилжүүлэх гэрээ хийх, дагалдах маягт бүртгэлийг хөтөлж бүртгэх</li></ul>

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
		<ul style="list-style-type: none"><li>- Эрх шилжүүлэхдээ дагалдах бичиг баримтыг бүрдүүлж ажиллах</li><li>- Аюултай хог хаягдлын тайланг жил бүрийн 11 сард гаргаж харьяа дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст албан тоотоор хандан хүргүүлэх</li><li>- Дээрх үйл ажиллагаануудын хууль эрх зүйн үндсийг доор тусгав. Үүнд:<ul style="list-style-type: none"><li>- <b>Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/</b></li><li>- <b>Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам /2018, 116-р тогтоол 1 дүгээр хавсралт/</b></li><li>- Хотын стандартыг хэрэгжүүлэн ажиллах Аюултай хог хаягдлын менежмент - <b>UCS 1703A</b></li></ul></li></ul>
5.	Химийн бодисын тээвэрлэлт, түүнтэй холбоотой аюул эрсдэл гарах /гэнэтийн осол аваар, техникийн бүрэн бус байдал, жолоочийн хариуцлагагүй байдал/	<ul style="list-style-type: none"><li>- Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх тавих шаардлага хэрэгжүүлэн ажиллах. /Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 12 дүгээр зүйл/</li><li>- Байгууллагын "Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө"-нд тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайтар нарийн тусгаж, химийн бодис тээвэрлэлтийн маршрутаа батлан хавсаргах</li><li>- Тус төлөвлөгөөнд "Бодисын асгаралд бага үед авах арга хэмжээ, саармагжуулах арга", "Бодисын асгаралд их үед авах арга хэмжээ, саармагжуулах арга"-ыг тус тус нарийвчлан тусгаж өгөх, харьяа дүүргийн ОБГ-аар шинэчлэн хянуулж батлуулах.</li><li>- Тогтоосон маршрутаас ангид тээвэр хийхийг хатуу хориглох</li><li>- MNS 4978:2017 Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээрээ тээвэрлэлтийг хийх</li><li>- Аюултай ачаа тээвэрлэх тусгай зөвшөөрөл авах</li><li>- Дадлага туршлагатай тээврийн ангилалд нийцсэн жолоочийг химийн бодисын аюул эрсдэлээс сэргийлэх сургалтад хамруулсны дараа химийн бодисыг тээвэрлэх тээвэрт явуулах</li><li>- Өөрсдөө тээвэр хийх боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл бүхий тээвэрлэлтийн компаниар тээвэрлэлтийг гүйцэтгүүлэх.</li></ul>
6.	Химийн бодис худалдан борлуулах үед бодис андуурагдах, замбараагүй борлуулалт хийх	<ul style="list-style-type: none"><li>- Химийн бодисыг "Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл" бүхий хуулийн этгээдэд худалдаалах</li><li>- "Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл"-д заасан хэмжээг хэтрүүлэхгүй байх</li><li>- Тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт болон аюултай бодис худалдахаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр, төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж, нэг хувийг худалдан авагчид, үлдсэн хувийг өөртөө хадгална. /Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 11 дүгээр зүйл/</li><li>- Худалдаалсан бодисын сав баглаа боодлыг эргүүлэн татаж авах</li></ul>

## ТАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

### 5.1 Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохицой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

### 5.2 Зорилт

- БОЕҮ-гээр дүгнэгдсэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллах
- Иргэдтэй нээлттэй харилцаж, байгаль орчинд халгүй нөхцөлийг бүрдүүлж хамтран ажиллах
- Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нутгийн иргэд болон засаг захиргааны нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллах зорилтуудыг тавьж ажиллана.

### 5.3 Хамрах хүрээ:

Манай төслийн хувьд хамрах хүрээгээ өөрийн төсөл хэрэгжих газар талбайд төдийгүй, харьяа нутаг дэвсгэрийн ус, хөрс, ан амьтан хамгаалах, сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэн ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт 9 2024 оны төлөвлөсөн БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Нийт зардал /мян.тог/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,994.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	3,000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежмент	4,250.0
7	Хог хаягдлын менежмент	2,050.0
8	Удирдлага зохион байгуулалт	-
9	БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	200.0
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	690.0
Нийт		12,184.0

## 5.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10 Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6		8	
<b>1. Агаар орчин</b>								
1	Агуулах болон орчинд төслийн үйл ажиллагаанаас агаарын бохирдол үүсгэх	Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд жилд 2 удаа шинжилгээ хийлгэх /2 цэгт/	Агуулах, агуулахын гадаад орчин	35	2 цэгт 2 удаа	700.0	удаа	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
2	Машин техникийн утаа	Орчны тоосожилт үүсгэхгүй байхад анхаарч, ил гарсан элэгдэлд орсон хөрсийг зүлэгжүүлэх	Төслийн эзэмшил газарт				удаа	
<b>2. Дуу чимээ</b>								
3	Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжийг дуу шуугиан хамгийн бага тараах нөхцөлтэйгээр байршуулан ашиглах	Машин тоног төхөөрөмжийг дуу шуугиан хамгийн бага тараах нөхцөлтэйгээр байршуулан ашиглах	Агуулах байранд	--*--	--*--	--*--	--*--	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.
4		Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Ажиллагсад	8	3 хүн, жил бүр	24.0	удаа	Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
5		Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийх. /Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори/	Агуулахын байранд, хашаанд	30	2 цэгт жилд 2 удаа	120.0	удаа	
<b>3. Усны нөөц, чанар</b>								
6	Төслийн явцад газрын гадарга, гүний ус бохирдуулах шууд бус нөлөөлөлтэй	Усны бохирдол үүсгэхээс урьдчилан сэргийлэх, ОХШХ хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	--*--	--*--	ҮАЗ-д тусгах	--*--	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль
<b>4. Хөрс, ургамлан бүрхэвч</b>								

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мянтөг	Тоо хэмжээ	Нийт зардал, мянтөг	Давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6		8
7	Ахуйн бохирдол үүсэх	Агуулах, лабораторийн байрны гадна хог хаягдлыг хадгалах зориулалтын битүүмжилсэн хогийн савны сайжруулалт хийх, ангилан ялгалттай болох	Агуулах, ёөрийн эзэмшил талбайн хогийн цэгт	--*--	--*--	500.0	--*--	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,
8		Хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлцуулж байх	Төслийн хүрээнд	--*--	--*--	--*--	--*--	MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
9	Химийн бодис алдагдах, ажиллагдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх;	Агуулах болон гадна талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх, аюултай хог хаягдлыг тусгайлсан түр хадгалах хогийн цэг гарган хадгалах	Агуулах, төслийн хүрээнд	--*--	--*--	500.0	--*--	Агуулах дотроо ангилан ялган тушаана гэж үзээд
10	Химийн бодис болон ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдаар хөрс бохирдох.	Агуулахын гадна орчинг зайлшгүй хэсгүүдийг хатуу хучилттай болгох, зүлэгжүүлэх, мод тарих, хог хаягдлын ангилан ялгалтыг байнга хянаж ажиллах	Агуулах болон эзэмшил талбайд	6.5	10	150.0	ш	
11	Холбогдох дурэм журмын хэрэгжилт хангагдахгүй байх хүн байгальд сөрөг нөлөөлөл үүсэх	Химийн бодисын болон аюултай хог хаягдлын тайлан гаргаж, холбогдох төр захиргааны байгууллагад цаг хугацаанд нь тайлагнах	Төслийн хүрээнд	--*--	--*--	--*--	--*--	
12		2 жил тутам байгаль орчны аудит хийлгэх	Төслийн хүрээнд	--*--	--*--	--*--	--*--	
<b>Эхний жилийн дүн</b>						<b>1,994.0</b>		

## 5.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Хүснэгт 11 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Нөхөн сэргээлт	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд харьяа хороо, дүүрэгтэй хамтран төлөвлөлттэйгөөр мод тарих, арчилан ургуулах	удаа	100	30.0	3000.0	4 эсвэл 10 дугаар сард	MNS 5914-2008- Байгаль орчин. Эвдэrsэн газрын нөхөн сэргээлт. Нэр томвёö, тодорхойлолт. MNS 5918:2008 Эвдэrsэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
Нийт						3000.0		

## 5.4 Нуулгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Тухайн төсөл хэрэгжих газар нь Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ба төслийн чиглэл, хүчин чадал, үйл ажиллагаатай холбоотойгоор хүн амыг нүүлгэх шаардлагагүй юм.

## 5.5 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй тус газар нь суурин бүсэд байрладаг. Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл байхгүй.

## 5.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

*Хүснэгт 12 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

№	Хог хаягдлын ангиалал	Хог хаягдал бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлзуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлзуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	удаа	350.0	Жил бүр	350.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
2	Аюултай хог хаягдлын хуримтлал үүсэх, ахуйн хог хаягдалтай холилдох	Химийн бодис, шингэн хог хаягдал асгарсан тохиолдолд тухай бүрт нь арилгаж байх материалыг /элс, хаягдал зориулалтын шингээгч даавуу гэх мэт/ нөөцлөн бэлдэх	Төслийн хүрээнд	удаа	200.0	Жил бүр	200.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд,
3		Агуулахын аюултай хог хаягдалыг ангилан ялгах тушаах	Төслийн хүрээнд	удаа	1,500.0	Эхний жил	1,500.0	
4		Аюултай хог хаягдал боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад хүлээлгэн өгөх	Төслийн хүрээнд	удаа	-	Жил бүр	-	
5	Хийн хаягдал гарч агаар орчин бохирдож болзошгүй. /бодисын шуудай, асгарсан бодис урвалж арчсан материалууд /	Худалдан авагч байгууллагаудтай гэрээлэн химийн бодисын сав баглаа боодлыг буцаан татах менежменттэй ажиллах	Төслийн хүрээнд	Тухай бүр	--*--	Тухай бүр	-	
<b>Эхний жилийн дүн</b>							<b>2,050.0</b>	

Хүснэгт 13 Осол эрсдэлийн менежмент

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Үрьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	2	3	4	5	6	7		
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн болон шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх. Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ. Химийн бодисоос үүсэх осол эрсдэл	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Барилга байгууламж техник тоног төхөөрөмжид	--*--	--*--	УАЗардалд	Гамшигаас хамгаалах тухай хууль, 27.1	
2		Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	Жил бүр	250	1,250.0		
3		Химийн бодистой харьцаж ажиллах ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт зохион байгуулах						
4		Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн хүрээнд	Жил бүр	--*--	УАЗардалд		
5		Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Төслийн хүрээнд	Жил бүр	-	УАЗардалд		
6		“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай” хуулийн 31.2-т “Шинээр ажлын байр бий болгох болон ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл өөрчлөгдөх бүрт, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэнэ” гэсэн заалтын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж байх.	Төслийн хүрээнд	Жил бүр	-	3,000.0	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай” хууль	
Эхний жилийн дүн						4,250.0		

*Хүснэгт 14 Удирдлага зохион байгуулалт ба осол эрсдэлийн төлөвлөгөө*

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар		
			2024 он						
			6 сар	8 сар	9 сар				
1	2	3	4	5	6	7			
1	Байгалийн гамшигт үзэгдэл түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ.	Галын болон байгалийн гамшигас урьдчилан сэргийлэх, гамшигийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сургалт мэдээлэл олгох		*		ХАБЭА менежер			
2	Үүсэж болзошгүй гэнэтийн осол аваар, галын аюул, цахилгаан техникийн гэмтэл.	Гамшигийн үед авах арга хэмжтээний төлөвлөгөөтэй байх		*		ХАБЭА менежер			
3	Менежментийн төлөвлөгөө хэрэгжилт алдагдах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлж үр дүнд дотоод хяналт тогтмол хийж байх			*	Байгаль орчны ажилтан			

*5.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө*

*Хүснэгт 15 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, төг /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	8
Агаарын чанар							

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, төг /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	8
1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Агуулахын байр, лаборатори тус бүрт 1 цэг сонгох. /нийт 2 цэг/	Жилд 2 удаа.	2*2	55	220.0	MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) MNS ISO 226:2003 Дуу чимээхэвийн норм
<b>Усны чанар</b>							
2	Унд ахуйн усны хяналтын шинжилгээ /хүнд металл, ерөнхий хими, микробиологи/	Унд ахуйн уснаас хагас жилд 1 удаа	Жилд 2 удаа.	2	115	230.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж
							MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
							MNS 13.060.50 Усны чанарын стандарт
<b>Хөрсний бохирдол</b>							
3	Хөрсний төлөв байдал, бохирдол /хөрсний механик бүрэлдэхүүн, хүнд металл/	Төслийн талбайгаас 1 цэг сонгох	Жилд 2 удаа.	2	120	240.0	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
<b>Эхний жилийн дүн</b>						<b>690.0</b>	

## ДҮГНЭЛТ

“Инно хими лба” ХХК нь “Пестицидийн үлдэгдэл тодорхойлох лаборатори болон өндөр мэдрэмжит багажит анализыг нутагшуулах, шаардлагатай химийн бодисуудыг импортлох, ашиглах, худалдаалах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны үнэлгээний зөвлөх байгууллага “Бурхан Буудай Бүтээмж” ХХК хийж гүйцэтгэлээ.

2024 оны төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 1 994 000 төгрөг, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд 3 000 000 төгрөг, осол эрсдэлийн төлөвлөгөөнд 4 250 000 төгрөг, хог хаягдлын төлөвлөгөөнд 2 050 000 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 690 000 төгрөг нийт **12 184 000** төгрөг зарцуулахаар төлөвлөж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу “Инно хими лаб” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн тайлант оны 11 дүгээр сарын 15-ны дотор Нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлэн хянуулах, мөн оны 12 дугаар сарын 15-ны дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах шаардлагатай.

